



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМД**

2024.08.05 № ТНАГ-2024/13-УТА-НА-02
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Алтанбулаг сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (*б.* хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**АЛТАНБУЛАГ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР
2024-2028**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

Алтанбулаг сум
2024 он

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД АЛТАНБУЛАГ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.21

Алтанбулаг сум

Уриа: АЛТАНБУЛАГЧУУДАА:

Алтанбулаг сумаа хамтдаа хөгжүүлцгээе

Монгол Улсын хөгжлийн Алсын харааг үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Алтанбулаг сумынхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор сум, орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Алтанбулаг сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд хөгжил дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

Зорилго: Хүний хөгжлийг нэн тэргүүнд тавьж, сайн засаглалаар оновчтой бодлого тодорхойлон, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

Зорилтууд:

1. Хүний хөгжлөөс нутгийн хөгжил чиглэнэ.
2. Хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэнэ.
3. Хүрээлэн буй орчин – Хөгжилд тэмүүлсэн Алтанбулагчуудаа дэмжинэ.
4. Хөдөлмөрч иргэн - Элбэг хангалуун амьдралд хөтөлнө.

Нэг. Хүний хөгжлөөс нутгийн хөгжил

1.1. Хүүхэд бидний- Ирээдүй

1.1.1. Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.2. Хүүхдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.3. Хүмүүжил, сурлага, урлаг, спортын чиглэлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх дугуйлан, секц, сонгоны төрлийг нэмэгдүүлж, чанарт анхаарна.

1.1.4. Эцэг эх, сурагчид руу чиглэсэн сургалт нөлөөллийн ажлуудыг эрчимтэй зохион байгуулж, хоорондын ойлголцлыг бий болгох замаар аз жаргалтай зэрэг уур амьсгалтай гэр бүлийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эсрэг зөрчлийг бууруулна.

1.1.5. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.1.6. Хүүхэд, залуучуудад чиглэсэн сэтгэл зүйн боловсрол олгох сургалт, уулзалтуудыг тогтмолжуулна.

1.1.7. Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг соёл, урлагийн чиглэлээр улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.

1.1.8. Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, сум орон нутгийнхаа түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

1.2. Залуус бидний - Итгэл

1.2.1. Спортын холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлж, багийн болон оюуны спортоор залуучуудыг хичээллэхийг бүх талаар дэмжиж ажиллана.

1.2.2. Малчин залуусыг хөгжүүлэх сургалт, уулзалт зөвлөгөөн, урлаг, спортын арга хэмжээг тогтмолжуулна.

1.2.3. Суманд дутагдалтай мэргэжлээр шилжин ирж ажиллах залуу боловсон хүчний нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэмжлэгийг бий болгоно.

1.2.4. Гадаад, дотоодод сурч, ажиллаж амьдарч буй нутгийн харьяат залуучуудтай эргэх холбоотой ажиллаж, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд санал хүсэлтийг тусгаж ажиллана.

1.3. Ахмадууд бидний - Бахархал

1.3.1 Ахмадуудаа 2 жил тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

1.3.2 Ахмадад чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааг тогтмолжуулж, байнгын цугладаг дасгал хөдөлгөөн хийх чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хамтдаа хөгжих нөхцөл бололцоог сайжруулна.

1.3.3 Ахмад настныг хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжоор хангана. Залуу үеийнхэнд зөвлөн туслахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.

1.3.4 “Ахмадын Өргөө” танхимыг жилийн 4 улиралд ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

1.3.5 Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч сум болно.

Хоёр. Хүртээмжтэй төрийн үйлчилгээ

2.1. Эрүүл хүн - Эрхэм жаргал

2.1.1. Сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдийг дэмжин дутагдалтай эмч, эмнэлгийн ажилтныг бодлогоор бэлтгэнэ.

2.1.2. Эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж хөрс, усны бохирдлыг багасгах цогц арга хэмжээ авснаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

2.1.3. “Эрүүл шүд”, “Эрүүл хүүхэд” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.4. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.5. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.

2.1.6. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.

2.1.7. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлнэ.

2.1.8. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.

2.1.9. Эрүүл мэндийн байгууллагыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр үе шаттай ханган, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай хүргэх, ая тухтай орчинд оношлох, эмчлэх боломж бүрдүүлнэ.

2.2. Оюунлаг, авъяаслаг, спортлог - Алтанбулагчууд

2.2.1. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд байлгана.

2.2.2. Бага, дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж, эцэг эхчүүдэд танилцуулж, үнэлүүлж хэвшүүлнэ.

2.2.3. Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

2.2.4. Тусгай хэрэгцээт *Хөгжлийн бэрхшээлтэй* хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг сайжруулна.

2.2.5. Хүүхэд багачуудыг улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.

2.2.6. Нийтийн номын сан, орон нутаг судлах танхимын сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.7. Соёлын төвийн мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, тоглолт, үзвэр үйлчилгээг тогтмолжуулах замаар иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.8. Соёлын төвийн хөгжим аппаратур, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг дээшлүүлнэ.

2.2.9. Сумын хэмжээнд үндэсний бөх, сур, шагайн харвааг Спорт цогцолборыг түшиглэн хөгжүүлнэ.

2.2.10. Тамирчдыг олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцоход зохих дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

2.2.11. Спорт цогцолборын барилгын засвар, тохижилт, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг дээшлүүлнэ.

2.3. Сайн засаглал – Сэтгэл ханамж

2.3.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг шинэ шатанд гаргаж, ил тод илүү шуурхай болгоно.

2.3.2. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангаж, орон нутгийн нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно.

2.3.3. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

2.3.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.3.5. Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлэх, сонсох ажиллагаа зохион байгуулах зэргээр иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.6. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санал санаачилга, хамтын ажиллагааг дэмжинэ.

2.3.7. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод, шилэн байлгана.

2.3.8. "Иргэнээ сонсьё" арга хэмжээг тогтмолжуулж, иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах, шуурхай шийдвэрлэх замаар төр, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

Гурав. Хүрээлэн буй орчин – Хөгжилд тэмүүлсэн Алтанбулагчууд

3.1. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт - Ая тухтай орчин

3.1.1. "Жишиг сум" хөтөлбөрийг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан үе шаттайгаар үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

3.1.2. Сумын төвийн айл өрхүүдийг төвийн халаалт, инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлнэ.

3.1.3. Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтад оруулж, иргэдийн эрүүл мэндийг үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.4. Сумын төвийн доторх 3.6 км хатуу хучилттай автозам тавих ажлыг үргэлжлүүлж, дуусгана.

3.1.5. Сумын төвийн авто замын дагуу явган болон дугуйн зам тавина.

3.1.6. Сумын төвийн гудамж, талбайн замыг үе шаттайгаар засч, гэрэлтүүлэг болон камержуулалтыг нэмэгдүүлж, иргэдийн зорчих нөхцөлийг сайжруулна.

3.1.7. Соёлын төвийн шинэ барилгыг ашиглалтад оруулж, иргэдийн соёлын үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.8. Төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоотойгоор "Жишиг гудамж" хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэн, сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулна.

3.1.9. Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдтэй хамтарч иргэдийн хашаа хороо засварлах ажлын мод, модон материалыг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.10. Хөл бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбайг засаж тохижуулан, хүүхэд, залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг нэмэгдүүлнэ.

3.1.11. Ерөнхий боловсролын сургуулийг урлаг, хоолны заалтай болгох, Дамбо цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын санхүүжилтийн асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

3.1.12. Цөх 3 дугаар багт байрлах гүүрнүүд, зорчиход хүндрэлтэй даваа гүвээ, замыг засаж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг сайжруулна.

3.1.13. Солдат толгой, Сэлэмт хөшөөг тохижуулж, нийтийн зам талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

3.1.14. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар ард иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангана.

3.2. Байгаль орчин, аялал жуулчлал - Ногоон хөгжил

3.2.1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

3.2.2. Хууль бус ан агнуур, мод бэлтгэлийг таслан зогсоож, байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглах бодлого барина.

3.2.3. Шахмал түлшний үйлдвэр байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж, айл өрхийг түлшээр хангаж, модны хэрэглээг багасгана.

3.2.4. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, байгаль орчинд хор нөлөөгүй үйлдвэрийг байгуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.

3.2.5. Цөлжилтөөс хамгаалах бодлого боловсруулж, мод үржүүлэг, ойжуулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах бодлого барьж ажиллана.

3.2.6. “Алтанбулаг-Хувьсгалын өлгий нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн байгалийн болон түүхэн, дурсгалт газруудыг баримтжуулж, хамгаалан, орчныг тохижуулж, ард түмэнд түгээн дэлгэрүүлж, таниулна.

3.2.7. Ардын хувьсгалын өлгий нутаг, байгалийн үзэсгэлэнт газар зэрэг орон нутгийн онцлогт суурилан нутгийн иргэдэд суурилсан аялал жуулчлалыг дэмжиж, орон нутгаа сурталчилна.

3.2.8. Алтанбулаг боомт, чөлөөт бүсийн гадна зам дагуу болон бусад нийтийн эзэмшлийн талбайд иргэд, аж ахуйн нэгжүүдэд стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээ эрхэлж, орлого олох боломжийг бүрдүүлэх худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалд зориулагдсан гудамж, талбайг байгуулна.

Дөрөв. Хөдөлмөрч иргэн - Элбэг хангалуун амьдрал

4.1. Хөдөө аж ахуй - Хөгжлийн тулгуур

4.1.1. Жимс, жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

4.1.2. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээнд жилийн турш тогтвортой нийлүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулна.

4.1.3. Газар тариалангийн усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.4. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

4.1.5. Газар ашиглалтыг сайжруулж, атаршсан газрыг эргэлтэд оруулж, малчны хоршоонд, тэжээлийн таримал тариалах зориулалтаар эзэмшүүлнэ.

4.1.6. Байгаль, экологи, бэлчээрийн даацтай уялдуулан малын тоо, төрөл, бүтцийг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

4.1.7. Аймгийн хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн малчин иргэдэд түгээн дэлгэрүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.

4.1.8. Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

4.1.9. Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.10. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ.

4.1.11. Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлнэ.

4.2. Баялаг бүтээгчид - Бидний бахархал

4.2.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

4.2.2. Алтанбулаг сумын бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг бүх талаар дэмжин сургалт, туршлага судлах аялал, арга хэмжээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

4.2.3. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлэх, өрсөлдөх хэмжээнд чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

4.2.4. Баялаг бүтээгчид болох өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн болон төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр хөнгөлттэй зээл тусламжид хамруулж, дэмжлэг үзүүлнэ.

4.2.5. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг эхлүүлнэ.

4.2.6. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнд үйлдвэр, барилгын салбарын анхан, дунд, эцсийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

4.2.7. Орон нутгийн онцлогт тохирсон бренд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван сум болно.

Алтанбулаг сумын МАН-ын Хорооноос сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ шударга, дайчин, хөдөлмөрч уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Алтанбулаг сумаа “ХАМТДАА ХӨГЖҮҮЛЦГЭЭ”.